



**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 31 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/831 дүгээр захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/831 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд байрлах “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилга II ээлжийн ажлын нэмэлт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Лхагважав)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (С.Цэдэнсодном)-т даалгасугай.

4.Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Энхбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 04 дугаар сарын 31-ний  
өдрийн 2/59 дүгээр тушаалын хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.ЛХАГВАЖАВ

(НХОГ-ын Зураг төслийн  
хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Т.БАТЗАЯА

(НЗДТГ-ын Хүний нөөцийн  
хөгжлийн төвийн менежер)

Г.МӨНХ-ЭРДЭНЭ

(НХОГ-ын Барилга  
захиалагчийн хэлтсийн  
Барилгын хяналтын инженер)

Ц.БЯМБАЖАВ

(Баянгол дүүргийн 5 дугаар  
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Х.ЭНХБААТАР

(НХОГ-ын Барилга  
захиалагчийн хэлтсийн  
Барилгын хяналтын инженер)